



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ**

2021 оны 01 сарын 12 өдөр

Дугаар 13

Мандалговь

«Автомашинд үнэлгээ тогтоож худалдах, үндсэн хөрөнгө акталж данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2, 77.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 30 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 1 дүгээр зүйлийн 1.2, 6 дугаар зүйлийн 6.2.1, 6.4.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг: Дундговь аймаг дахь Цагдаагийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 10,000,000 /арван сая/ төгрөгийн балансын үнэтэй, үлдэгдэл өртөггүй “Sanya” маркийн 5 ширхэг мотоциклийг нэгдүгээр хавсралтаар актлаж данснаас хасах, 15,000,000 /арван таван сая/ төгрөгийн балансын үнэтэй, 7,499,996 /долоон сая дөрвөн зуун ерэн есөн мянга есөн зуун ерэн зургаа/ төгрөгийн үлдэгдэл өртөгтэй УАЗ-315142-012, УАЗ-31512 маркын 2 ширхэг автомашины хоёрдугаар хавсралтаар худалдах доод үнийг тус бүр 1,000,000 /нэг сая/ төгрөгөөр, 6,000,000 /зургаан сая/ төгрөгийн балансын үнэтэй, 1,958,333 /нэг сая есөн зуун тавин найман мянга гурван зуун гучин гурав/ төгрөгийн үлдэгдэл өртөгтэй Хьондай аксент маркын 2 ширхэг автомашиныг хоёрдугаар хавсралтаар худалдах доод үнийг тус бүр 500,000 /таван зуун мянга/ төгрөгөөр тогтоон нээлттэй дуудлага худалдаагаар худалдахыг зөвшөөрсүгэй.

Хоёр: Дундговь аймаг дахь Цагдаагийн газрын дарга (Г.Наранбаатар)-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

- 2.1 Эд хөрөнгийг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтад дор акталж, устган, данснаас хассаны дараа холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх.
- 2.2 Эд хөрөнгийг худалдсаны дараа холбогдох хууль, журмын дагуу данс бүртгэлээс хасах
- 2.3 Энэ тогтоолын биелэлтийг 2021 оны 1 дүгээр улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.


Гурав: Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.ОД-ЭРДЭНЭ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2021 оны 01 дүгээр сарын
12-ний өдрийн 3 тогтоолын нэгдүгээр хавсралт



Цагдаагийн газрын актлах хөрөнгийн мэдээлэл

№	Тээврийн хэрэгслийн төрөл	Марк	Улсын бүртгэлийн		Үйлдвэрлэсэн он	Ашиглалтад орсон огноо	Тээврийн хэрэгслийн		Нийт гүйлт /км/	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Данснаас хасах болсон шалтгаан
			сери	дугаар			арлын дугаар	моторын эзлэхүүн					
1	Мотоцикл	Sanya	ДУЗ	49-92	2017	17.07.25	LKIPCKL14H 1091705	SY150-6	201541	2,000,000	2,000,000	-	Ашиглалтын хугацаа дууссан
2	Мотоцикл	Sanya	ДУЗ	49-91	2017	17.07.25	LKIPCKL10H 1091708	SY150-6	245894	2,000,000	2,000,000	-	Ашиглалтын хугацаа дууссан
3	Мотоцикл	Sanya	ДУЗ	49-95	2017	17.07.25	LKIPCKL17H 1091696	SY150-6	195841	2,000,000	2,000,000	-	Ашиглалтын хугацаа дууссан
4	Мотоцикл	Sanya	ДУЗ	49-90	2017	17.07.25	LKIPCKL18H 1001710	SY150-6	368448	2,000,000	2,000,000	-	Ашиглалтын хугацаа дууссан
5	Мотоцикл	Sanya	ДУЗ	49-93	2017	17.07.25	LKIPCKL12H 1091718	SY150-6	245879	2,000,000	2,000,000	-	Ашиглалтын хугацаа дууссан
ДҮН										10,000,000	10,000,000	-	

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2021 оны 11 дүгээр сарын
12 ний өдрийн 3 тогтоолын хоёрдугаар хавсралт



Цагдаагийн газрын дуудлагаар худалдах тээврийн хэрэгслийн мэдээлэл

№	Тээврийн хэрэгслийн төрөл	Марк	Улсын бүртгэлийн		Үйлдвэрлэсэн он	Ашиглалт ад орсон огноо	Тээврийн хэрэгслийн		Нийт гүйлт /км/	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Данснаас хасах болсон шалтгаан
			сери	дугаар			арлын дугаар	моторын эзлэхүүн					
1	Суудлын	УАЗ-315142-012	ДУА	99 00	2012	12.12.31	315100С0526262	В-2445	368945	8,500,000	4,250,004	4,249,996	Ашиглалтын шаардлага хангахгүй болсон
2	Суудлын	УАЗ-31512	ДУА	03 33	2008	08.10.31	ХТТ31512280561780	В-2445	387510	6,500,000	3,249,999.96	3,250,000	Ашиглалтын шаардлага хангахгүй болсон
3	Суудлын	Хьюндай аксент	ДУЭ	22 71	2006	10.07.07	КМНСМ41А АВУ546984	В-1500	275811	3,500,000	1,749,999.96	1,750,000	Ашиглалтын шаардлага хангахгүй болсон
4	Суудлын	Хьюндай аксент	ДУЭ	79 97	2008	08.12.31	КМНСМ41А Р8У276068	В-1500	235250	2,500,000	2,291,666.52	208,333	Ашиглалтын шаардлага хангахгүй болсон
ДҮН										21,000,000	11,541,670.44	9,458,329	